

СҮХБААТАР АЙМГИЙН СҮХБААТАР СУМ ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН 2022 ОНЫ 10 ДУГААР САРЫН МЭДЭЭ

Төрийн удирдлагын чиглэлээр:

Сүхбаатар сумын ИТХ, Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөлтэй хамтран гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зорилготой **"Зөвөөр зөвлөө урьдчилан сэргийлье"** уриатай нэг сарын аянг эхлүүлсэн. Аяны хүрээнд ИТХ-тай хамтран 2022.10.20-ны өдөр Аймгийн Цагдаагийн газар, Прокурорын газар, Шүүхийн байгууллагаас иргэдэд гэмт хэргээс урьдчилан сэргийлэх уулзалт, яриаг зохион байгуулалаа. Аяны хүрээнд Гэр бүл судлаач Ж.Баясгалан төрийн албан хаагчид, ЕБС-ийн сурагчид болон иргэдийн дунд сонирхолтой яриаг хүргэсэн. Танхимаар 135 хүнийг хамруулсан.

Монголын багш нарын баярыг угтаж Засаг даргын нэрэмжит цэцэрлэг, бага, дунд боловсролын багш нарын дунд ур чадварын тэмцээн зохион байгууллаа.

Намрын цэрэг татлагын ажил зохион байгуулагдаж 15 залуу Сүхбаатар болон Дорнод аймгуудад цэргийн алба хаахаар татагдсан.

Байгаль орчин , Хөдөө аж ахуйн чиглэлээр:

2017 оноос Засаг даргын Тамгын газраас санаачлан хэрэгжүүлж байгаа цөөн малтай малчин өрхийг малжуулах журмын дагуу хөтөлбөрт хамрагдахаар сонгогдсон 5 багийн 12 малчин өрхөд тус бүр 80 эм хонь, 3 төрийн албан хаагчид тус бүр 50 эм хонь хүлээлгэн өгөх ажлыг зохион байгууллаа.

2022 оны 10 сарын 10 өдөр Сүхбаатар аймгийн Баруун-Урт суманд “Малчдын зөвөлгөөн”-ийг зохион байгуулж, аймгийн ХХААГ, БОАЖГ, УЦУОШГ, Мал эмнэлэг, ГХБХБГ зэрэг мэргэжлийн байгууллагын мэдээлэл, төслийн танилцуулга, малчдын санал, бодол, асуулт, хариулт зэрэг олон чиглэлээр ярилцаж, зөвлөлдлөө. Зөвлөгөөнд 14 хүн оролцлоо. Үүнээс 10 нь малчин, сумын засаг дарга, ХАА-н мэргэжилтэн, цаг уурын мэргэжилтэн, БОХУБайцаагч оролцож, санал бодлоо солилцлоо.

Сүхбаатар аймаг ХХААГ, Эрүүл мэндийн газар, МХГазар, Боловсрол, шинжлэх ухааны газар, стандарт, хэмжил зүйн газар, Монголын тогоочдын холбоо, сумын ЗДТГазар хамтран 2022.10.22-23 ны өдрүүдэд ”Бүсийн тогооч, зөөгчийн сургалт ур чадварын уралдаан-2022” арга хэмжээг Улсын тэргүүний Түмэнцогт суманд амжилттай зохион байгуулагдлаа. Сургууль, цэцэрлэгийн хоол, эмнэлэг эмчилгээний хоол, ресторан зоогийн газрын хоол, орон нутгийн брэнд хоол, орчин цагийн монгол хоол, нарийн боов үйлдвэрлэл, зөөгчийн ур чадвар, мөн спорт, урлагаар оролцогчид маань ур чадвараа сорьлоо. Уг арга хэмжээнд сумаа төлөөлөн мэргэжлийн 6 тогооч оролцсон байна.

2022-2023 оны өвөл хаврын өвөлжилтөнд зориулан сумын аюулгүй нөөцөнд 90 тн өвс бэлтгээд байна.

Тэрбум мод үндэсний хөдөлгөөний хүрээнд орон нутагт 400 ширхэг, Олгой булаг ХХК, Каскайд майнинг ХХК-ууд 10-12 эгнээ нийт 400 метр газарт сумын салхин дээд талд ойн зурвас байгуулах зорилгоор өөрсдийн хөрөнгөөр 2000 ширхэг улиас модыг мэргэжлийн байгууллагаар тариулж байна.

Сумын 4-р багийн нутаг Зараагийн 1,3 га эвдэрсэн газарт Цайрт минераль ХХК нөхөн сэргээлтийг хийсэн ба 5-р багийн нутаг Таван толгой гэх газарт замын хажууд гаргасан каррейрт үүссэн хогийг булшлах, нөхөн сэргээлт хийх ажлыг Талын гал ХХК гүйцэтгэлээ.

Мөн арван хайлаасны шавар авдаг 1,5 га эвдэрсэн газрыг Каскейд майнинг ХХК нөхөн сэргээлт хийж гүйцэтгээд байна.

2021 онд шинээр бий болгосон нэгдсэн хогийн цэгийн отвол шороон дээгүүр 300 мерт торон хашааг салхин доод татуулаад байна. Мөн тус хогийн цэгийн хажууд эмнэлгийн аюултай хог хаягдлын цэгийг байгуулаад байна.

Тус сумын 5,3,1-р багийн нутагт цагаан зээр тархан байршиж байгаатай холбогдуулан өдөр, шөнийн эргүүлийг энэ сард 7 удаа хийж 7 зөрчил илрүүлэн, холбогдох хууль журмын дагуу арга хэмжээ тооцсон байна.

10.13 нд их цэвэрлэгээ зохион байгуулсан. Тус цэвэрлэгээнд албан байгууллага ААНэгж үйлчилгээний газрууд өөрсдийн цэвэрлэх хувиартай нийтийн эзэмшлийн газруудыг цэвэрлэв. Нийт 10 орчим тонн хог хаягдлыг цэвэрлэсэн.

Эрүүл мэнд, Боловсролын чиглэлээр:

Тайлант оны 10 сарын 25-ны байдлаар:

ЭМТөвд төрсөн эх – 4

Нийт төрсөн эх – 54

Нас баралт – 14

Эмнэлэгт хэвтэн эмчлүүлэгч – 385

Ор хоног – 2974

Нийт үзлэг – 7054

Эрэгтэй – 3177

Эмэгтэй – 3877

Урьдчилан сэргийлэх үзлэг – 3781

Идэвхитэй хяналт – 2816

Жирэмсний хяналт-40/50/80%

Амбулаторийн үзлэг – 1219

Анхан – 476

Давтан – 743

Гэрийн дуудлага – 548

Халдварт өвчлөл – 1547

Шинэ-892

Хуучин -655

Түргэн тусламжийн дуудлага – 813
Алсын дуудлага – 265
Осол гэмтлийн дуудлага – 10
Эрт илрүүлэг үзлэг

Хөхний өмөн – 690/295/42,7 %
Умайн хүзүүний өмөн – 232/80/34,4%
Артерийн даралт ихдэлт – 1970/1160/92,8%
Чихрийн шижин – 1250/1209/96,6%

Сургалт сурталчилгаа

Тараах материал-13 төрөл 6500 ширхэг
Цахим хуудас-283 төрлийн мэдээлэл байршуулж 38000 хүний хандалт
Танхимын сургалт -18 удаа 480 хүн хамруулсан

“Вируст гепатит, элэгний хавдрыг эрт илрүүлэх төсөл”, “Элэгний С вирусгүй Сүхбаатар” хөтөлбөрийн хүрээнд нийт 380 хүнийг илрүүлэг шинжилгээнд хамруулж С вирустэй илэрсэн 17 хүнийг тоолуулах шинжилгээнд илгээсэн.

ЕБС-ын 7,8 ангийн 43 сурагчдад “Гарын эрүүл ахуй” “Амьсгалын замаар дамжин халдварладаг өвчинүүд” сэдвүүдээр сургалт зохион байгууллаа.

ЕБС, СӨБ-ийн туслах багш, үйлчлэгч нарт “Ариутгал халдваргүйтгэл хийх “Ариутгал халдваргүйжүүлэлтийн бодисын зөв зохистой хэрэглээ” сэдвүүдээр сургалт зохион байгууллаа.

Байгууллагын нийт ажилчдыг эрүүл мэндийн сайдын 537 –р тушаалын 6 дугаар хавсралтын маягт 1 –ын дагуу урьдчилан сэргийлэх үзлэгийг зохион байгуулсан.

Аймгийн хэмжээнд зохион байгуулагдсан “Хүүхдийн хөгжлийн үнэлгээний арга зүй” сэдэвт 3-н өдрийн сургалтанд эрхлэгч, аргазүйч нар хамрагдсан.

Тогтвортой хөгжлийн боловсрол Олон улсын ЭКО сургууль, цэцэрлэг хөтөлбөрийн анхан шатны 3 дахь сургалтанд эрхлэгч, аргазүйч, бүлгийн багш, туслах багш нар 2 өдрийн сургалтанд амжилттай хамрагдаж сертификатаа гардан авсан.

6-н бүлгийн эцэг эх, хүүхүүдийн “Алтан намар” өдөрлөгийг жил бүр уламжлал болгон зохион явуулдаг. Үүнд А.Эрдэнэболор багштай Бөжинхөн ахлах “А” бүлэг Тэргүүн байр, Н.Болортуяа багштай “Дэгдээхий бага” бүлэг Дэд байр, Л.Нарангэрэл багштай “Хэрэмхэн” ахлах “Б” бүлэг Гутгаар байр тус тус эзэлсэн.

Багш нарын баярыг угтан сумын Засаг даргын нэрэмжит “Чадварлаг багш” ур чадварын уралдааныг зарлаж Тэргүүн байр Э.Нямгэрэл, Дэд байр Б.Гэрэлтуяа, Гутгаар байр Т.Уугантулга нар тус тус шалгарсан.

Соёл урлагийн чиглэлээр:

Монгол улсын Соёлын яамны санхүүжилтээр “Зүүн Бүсийн Жишиг Соёлын Төв”-ийн тоглолтын танхимд “**Тайзны иж бүрэн хөшиг**”-ний хөрөнгө оруулалт хийгдлээ. “Хөшиг экспо” ХХК нийлүүлэв.

Монгол улсын Соёлын яамны хөрөнгө оруулалтаар Зүүн бүсийн жишиг соёлын төвд үндэсний хөгжим нийлүүлэх тендер шалгаруулалт зарлагдсан. Тендерт “Эгшиглэн магнай” ХХК шалгарч, 8 нэр төрлийн 12 ширхэг үндэсний хөгжмүүдээ 2022.10.20-ны өдөр хүлээж авсан. Мальт бөмбөр 1ш, Хуучир 1ш, дунд гарын Шанз 1ш, Морин хуур 2, дунд гарын Ёочин хөгжим 1ш, 13 утастай Ятга 2ш, Хулсан хуур 2ш, Лимбэ 2ш зэрэг нийтдээ **4.563.900** төгрөгний “**Үндэсний хөгжмийн хөрөнгө оруулалт**” хийгдсэн.

“Олон улсын ахмадын баяр”-т зориулж дугуйлангийн сурагчдын урлагийн тоглолт, баярын цэнгүүний арга хэмжээг зохион байгууллаа.

“Дэлхийн багш нарын 28, Монголын багш нарын 56 дахь өдөр”-т зориулсан "Баярын хурал", Улсын тэргүүний хүүхдийн цэцэрлэг, Ерөнхий боловсролын сургуулийн сурагчдын хамтарсан "Хүндэтгэлийн тоглолт"-ыг зохион байгуулж, танхимаар 160 хүнийг хамруулсан.

“Бид таньруу” зөөврийн номын сангийн үйлчилгээгээр 5-р баг буюу “Шинэ булаг” багийн малчин өрхийн 65 хүнд угийн бичгийн сургалт, зөөврийн номын сангийн үйлчилгээ үзүүлсэн.

“Номын баяр-2022” ном унших соёл түгээх аяны хүрээнд Улсын тэргүүний цэцэрлэгийн ахлах ,дунд бүлгийн 45 хүүхдүүдэд өөрөө ярьдаг вазаль тоглоом эвлүүлэх,монгол ардын үлгэр ,танин мэдэхүйн 15 ширхэг номоор зөөврийн номын сангийн үйлчилгээ зохион явуулсан. Соёлын яамны санхүүжилтээр 500,000 төгрөгний 32 ширхэг хүүхдийн номоор **баяжилт** хийгдэж, номоо хүлээж авсан. Шинэ номонд техник ажиллагаа хийж, Шинэ номын үзэсгэлэнг танхимаар зохион явуулан 90 хүүхдэд хүргэсэн.

Номын баяр -2022 арга хэмжээний хүрээнд **“НАЙРГИЙН ОРНЫ НАЙРАГЧ ХҮҮХДҮҮД”** уран уншлагын уралдааныг цэцэрлэг, бага анги, дунд анги гэсэн 3-н төрлөөр зохион явуулсан . Нийт 68 хүүхэд хамрагдсан.

Монгол Улсын Ерөнхийлөгчийн зарлигаар нийтээр тэмдэглэх **"НОМЫН БАЯР-2022"** нээлттэй хаалганы өдөрлөгийг Улсын Тэргүүний Номын сан, Сүхбаатар сумын Ерөнхий боловсролын сургуулийн номын сантай хамтран 2022.10.19-ний өдөр амжилттай зохион байгууллаа.

Номын баярын хүрээнд "Ханын сонины уралдаан", "Найрагч орны найрагч хүүхдүүд" анхан шатны уралдааны шагнал гардуулах үйл ажиллагаа, "Номын хавчуургын үзэсгэлэн", "Хүүхдийн шинэ номын үзэсгэлэн", "Алтан-хонх" танин мэдэхүйн тэмцээн зэрэг багц ажлууд тус тус зохион байгуулагдсан.

Мөн "Судар эгшиглэн" төслийн шилдэг оролцогч И.Даваадуламыг уншигч хүүхдүүдтэй уулзуулан, номын унших, номын тэмдэглэл хөтлөх талаар заавар зөвлөгөөг хүргэж, Номын баяр-2022 өдөрлөгийн хүрээнд **"НОМЫН СОЁЛЫГ ТҮГЭЭЦГЭЭЕ"** уриалгыг гаргасан.

Монгол улсын **"Түүх, соёлын үл хөдлөх дурсгалын улсын тооллого"** 2022 оны 10 дугаар сарын 10-14-ний хооронд Сүхбаатар суманд амжилттай зохион байгуулагдлаа. Түүх соёлын үл хөдлөх дурсгалын улсын тооллогыг 4 өдрийн дотор хийж гүйцэтгэн, Соёлын

яамнаас гаргасан тооллогын дэвтрийг үндэслэн нийт 22 дурсгалт газрын 60 ширхэг дурсгалыг тоолохоор төлөвлөснөөс шинээр Цагаан дэрсний булшийг илрүүлж, нийт 16 булш нэмж бүртгэсэн.

Тооллогын турш нийтдээ 960 км замыг туулж тус Сүхбаатар сумын нутаг дэвсгэр дээрх түүх, соёлын үл хөдлөх **22** дурсгалт газрын **76** дурсгалт зүйлийг тооллогод хамруулж, 224 ширхэг гэрэл зураг, 4 минут орчмын дүрс бичлэгээр баримтжууллаа.

МЭДЭЭ ГАРГАСАН :

Хууль, эрх зүйн мэргэжилтнийг түр орлон гүйцэтгэгч:

Э.Дэлхийцэцэг

ХЯНАСАН:

Засаг даргын Тамгын газрын дарга

/Ц.Сүхболд/